БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

# ЖАРГАЛАНТ СУМЫН СУМ ДУНДЫН ЭМНЭЛГИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**АУДИТЫН КОД:** БНА-2021/162/СТА-ТШЗ


Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням

Утас: 88089024 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Ахлах аудитор: М.Алтантуяа

Утас: 99890393 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn


Баянхонгор
2021 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

005

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт/эх хувь/ ........ 3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан........ 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 9
3.Аудитын тайлан ........ 10
3.1. Ерөнхий зүйл ........ 10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ........ 10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт........ 11
3.4. Материаллаг байдал ........ 11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ........ 11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт........ 12
3.7. Шилэн дансны мэдээлэл ........ 13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 14
3.9. Аудитын илрүүлэлт ........ 14
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил ........ 14
Аудитын зөвлөмж ........ 14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд........ 14
4. Менежментийн захидал........ 15
5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт........ 17

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2021. 02. 10 № 2/21

танай ______________ -ны №______________ -т

ЖАРГАЛАНТ СУМЫН СУМ
ДУНДЫН ЭМНЭЛГИЙН ЭРХЛЭГЧ
Г.АЛТАНТУЯА ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Жаргалант сумын Сум дундын эмнэлгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Жаргалант сумын Сум дундын эмнэлгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Жаргалант сумын Сум дундын эмнэлгийн 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон

удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **35,722,858.06** | **54,743,252.47** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 35,722,858.06 | 54,743,252.47 |
| **351** | **Түүхий эд материал** | 00.00 | 10,837,320.65 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 00.00 | 6,859,360.36 |
| 35130 | Эм боох материал | 00.00 | 3,977,960.29 |
| **354** | **Хангамжийн материал** | 35,722,858.06 | 43,905,931.82 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,514,850.00 | 1,635,150.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 27,440,387.76 | 35,662,197.76 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 00.00 | 555,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 694,584.06 | 1,190,600.06 |
| 35450 | Барилгын засварын материал | 4,111,700.00 | 3,811,700.00 |
| 35460 | Хүнсний материал | 1,287,196.00 | 953,284.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 674,140.24 | 98,000.00 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **690,877,983.02** | **704,914,850.06** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 690,877,983.02 | 704,914,850.06 |
| **392** | **Биет хөрөнгө** | 677,276,358.02 | 691,171,141.69 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 768,280,280.00 | 828,338,254.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -215,379,942.46 | -225,734,297.02 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 34,835,000.00 | 34,835,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -13,492,958.34 | -19,911,458.34 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 274,544,989.70 | 273,080,479.30 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -182,606,606.75 | -210,047,783.46 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 23,841,161.00 | 25,987,161.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -13,617,250.13 | -16,247,898.79 |
| 39217 | Ном | 871,685.00 | 871,685.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 13,601,625.00 | 13,743,708.37 |
| 39301 | Програм хангамж | 980,000.00 | 1,055,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -684,375.00 | -617,291.63 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 13,306,000.00 | 13,306,000.00 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **726,600,841.08** | **759,658,102.53** |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **726,600,841.08** | **759,658,102.53** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 726,600,841.08 | 759,658,102.53 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 605,279,606.00 | 605,279,606.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 605,279,606.00 | 605,279,606.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -237,040,373.09 | -203,983,111.64 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -237,040,373.09 | -237,040,373.09 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 33,057,261.45 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 358,361,608.17 | 358,361,608.17 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **726,600,841.08** | **759,658,102.53** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **500,738,540.00** | **623,838,426.65** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **5,000,300.00** | **70,579,838.65** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 5,000,300.00 | 70,579,838.65 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 5,000,300.00 | 70,579,838.65 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 300.00 | 610,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 5,000,000.00 | 69,969,838.65 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **495,738,240.00** | **553,258,588.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 471,172,400.00 | 512,311,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 471,172,400.00 | 512,311,700.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 277,900.00 | 12,130,666.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 11,822,766.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 277,900.00 | 307,900.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 24,287,940.00 | 28,816,222.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 24,287,940.00 | 28,816,222.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **524,731,400.68** | **590,781,165.20** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **524,731,400.68** | **590,781,165.20** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 523,852,881.68 | 585,205,717.47 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 312,515,921.00 | 359,922,176.27 |
| 210101 | Үндсэн цалин | 312,499,921.00 | 216,067,000.00 |
| 210102 | Нэмэгдэл | 16,000.00 | 105,283,240.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 6,581,448.63 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 31,990,487.64 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 39,014,479.00 | 44,855,586.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 30,821,189.00 | 30,694,100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,012,252.00 | 3,416,686.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,805,150.00 | 2,865,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 251,385.00 | 716,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,124,503.00 | 7,163,200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 39,149,516.00 | 38,557,576.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,692,516.00 | 3,583,176.00 |
| 210302 | Түлш, халаалт | 36,107,000.00 | 34,896,400.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 350,000.00 | 78,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 23,790,462.00 | 24,401,345.24 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,282,350.00 | 3,617,020.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,322,214.00 | 15,288,584.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 268,800.00 | 560,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 31,156.00 | 70,101.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,885,942.00 | 4,865,640.24 |
| **2105** | **Нормативт зардал** | 51,809,525.00 | 52,183,587.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 40,903,511.00 | 41,602,875.00 |
| 210502 | Хоол, хүнс | 10,906,014.00 | 10,580,712.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,674,500.00 | 9,334,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,674,500.00 | 9,334,200.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,506,000.00 | 1,505,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,506,000.00 | 1,505,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,978,990.00 | 2,392,240.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 277,900.00 | 602,300.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 120,000.00 | 119,250.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 83,860.00 | 104,360.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 36,500.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,394,200.00 | 1,466,800.00 |
| 210807 | Газрын төлбөр | 66,530.00 | 66,530.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 49,413,488.68 | 52,054,006.96 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,939,120.00 | 2,611,900.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 45,474,368.68 | 49,442,106.96 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 878,519.00 | 5,575,447.73 |

| | | | |
|---|---|---|---|
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 770,000.00 | 5,101,366.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 00.00 | 4,443,366.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 770,000.00 | 658,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 108,519.00 | 474,081.73 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 108,519.00 | 474,081.73 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-23,992,860.68** | **33,057,261.45** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-23,992,860.68** | **33,057,261.45** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **495,738,540.00** | **553,868,588.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **300.00** | **610,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 300.00 | 610,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 300.00 | 610,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 300.00 | 610,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **495,738,240.00** | **553,258,588.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 471,172,400.00 | 512,311,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 471,172,400.00 | 512,311,700.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 277,900.00 | 12,130,666.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 11,822,766.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 277,900.00 | 307,900.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 24,287,940.00 | 28,816,222.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 24,287,940.00 | 28,816,222.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **486,068,540.00** | **550,527,588.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **486,068,540.00** | **550,527,588.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **485,190,021.00** | **544,770,140.27** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 312,515,921.00 | 359,922,176.27 |
| 210101 | Үндсэн цалин | 205,721,175.00 | 216,067,000.00 |
| 210102 | Нэмэгдэл | 78,495,016.00 | 105,283,200.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,006,000.00 | 6,581,488.63 |
| 210104 | Урамшуулал | 22,293,730.00 | 31,990,487.64 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 39,014,479.00 | 44,855,586.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,903,007.00 | 30,694,100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,241,797.00 | 3,416,686.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,637,899.00 | 2,865,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 648,182.00 | 716,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,583,594.00 | 7,163,200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 39,732,316.00 | 38,255,176.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,407,516.00 | 3,583,176.00 |
| 210302 | Түлш, халаалт | 35,974,800.00 | 34,594,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 350,000.00 | 78,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 23,489,104.00 | 22,475,021.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,357,350.00 | 966,720.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,323,798.00 | 15,287,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 183,800.00 | 360,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,799,156.00 | 2,211,301.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,825,000.00 | 3,650,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 54,836,811.00 | 59,081,531.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 41,230,011.00 | 44,274,731.00 |
| 210502 | Хоол, хүнс | 10,026,800.00 | 9,476,800.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,580,000.00 | 5,330,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,060,000.00 | 9,589,200.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 360,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,700,000.00 | 9,589,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,506,000.00 | 1,505,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,506,000.00 | 1,505,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,086,290.00 | 3,603,140.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 277,900.00 | 822,300.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 20,000.00 | 00.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 120,000.00 | 119,250.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 80,000.00 | 80,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 33,000.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,666,800.00 | 1,666,800.00 |
| 210807 | Газрын төлбөр | 73,890.00 | 66,530.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 99,000.00 | 98,960.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 715,700.00 | 716,300.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,949,100.00 | 5,483,310.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,949,100.00 | 5,483,310.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **878,519.00** | **5,757,447.73** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 770,000.00 | 5,283,366.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 4,743,366.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 770,000.00 | 540,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 108,519.00 | 474,081.73 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 108,519.00 | 474,081.73 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **9,670,000.00** | **3,341,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **9,670,000.00** | **3,341,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **9,670,000.00** | **3,341,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 9,670,000.00 | 3,341,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 9,670,000.00 | 3,341,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-9,670,000.00** | **-3,341,000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| **Код** | **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Засгийн газрын хувь оролцооны нийт дүн** |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2019 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл | 605,279,606.00 | 358,361,608.17 | -213,047,512.41 | 750,593,701.76 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -23,992,860.68 | -23,992,860.68 |
| C08 | 2019оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 605,279,606.00 | 358,361,608.17 | -237,040,373.09 | 726,600,841.08 |
| D01 | 2020 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл | 605,279,606.00 | 358,361,608.17 | -237,040,373.09 | 726,600,841.08 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 605,279,606.00 | 358,361,608.17 | -237,040,373.09 | 726,600,841.08 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 33,057,261.45 | 33,057,261.45 |
| D09 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 605,279,606.00 | 358,361,608.17 | -203,983,111.64 | 759,658,102.53 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 544,717,000.00 | 540,653,840.27 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 544,717,000.00 | 540,653,840.27 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 540,596,000.00 | 540,113,840.27 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 358,159,300.00 | 357,922,176.27 |
| 210101 | Үндсэн цалин | 214,067,000.00 | 214,067,000.00 |
| 210102 | Нэмэгдэл | 105,283,200.00 | 105,283,200.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,699,000.00 | 6,581,488.63 |
| 210104 | Урамшуулал | 32,110,100.00 | 31,990,487.64 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 44,770,500.00 | 44,605,586.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 30,444,100.00 | 30,444,100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,581,600.00 | 3,416,686.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,865,300.00 | 2,865,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 716,300.00 | 716,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,163,200.00 | 7,163,200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 38,294,900.00 | 38,255,176.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,622,100.00 | 3,583,176.00 |
| 210302 | Түлш, халаалт | 34,594,800.00 | 34,594,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 78,000.00 | 78,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 22,504,200.00 | 22,475,021.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 966,800.00 | 966,720.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15,316,000.00 | 15,287,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 360,000.00 | 360,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,211,400.00 | 2,211,301.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,650,000.00 | 3,650,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 54,081,600.00 | 54,081,531.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 39,274,800.00 | 39,274,731.00 |
| 210502 | Хоол, хүнс | 9,476,800.00 | 9,476,800.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5,330,000.00 | 5,330,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 12,140,000.00 | 12,139,200.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,550,000.00 | 2,550,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 9,590,000.00 | 9,589,200.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,506,400.00 | 1,505,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,506,400.00 | 1,505,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,139,100.00 | 3,130,840.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 350,000.00 | 350,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 120,000.00 | 119,250.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 80,000.00 | 80,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 33,000.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,666,800.00 | 1,666,800.00 |
| 210807 | Газрын төлбөр | 74,000.00 | 66,530.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 99,000.00 | 98,960.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 716,300.00 | 716,300.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 6000000.00 | 5999310.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,000,000.00 | 5,999,310.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 4121000.00 | 540000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 4,121,000.00 | 540,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,121,000.00 | 540,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 544,717,000.00 | 540,653,840.27 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 515,892,700.00 | 511,837,618.27 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 515,892,700.00 | 511,837,618.27 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 28,824,300.00 | 28,816,222.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 28,824,300.00 | 28,816,222.00 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 27.00 | 29.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 19.00 | 20.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 07.00 | 08.00 |
| **64** | **ЭМЧЛҮҮЛЭГСДИЙН ТОО** | 00.00 | 363.00 |
| 640001 | Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо | 00.00 | 363.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **26.00** | **29.00** |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 20.00 | 21.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 06.00 | 08.00 |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Жаргалант сумын Сум дундын эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Жаргалант сумын Сум дундын эмнэлгийн эрхлэгч Г.Алтантуяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 05-аас 2021 оны 02 дугаар сарын 08–ны хооронд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Жаргалант сумын Сум дундын эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 136 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Жаргалант сумын Сум дундын эмнэлгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд: Ард иргэдэд эрүүл мэндийн чанартай үйлчилгээ үзүүлэх гэсэн зорилттой ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.



005

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Жаргалант сумын Сум дундын эмнэлгийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Эрүүл мэндийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд Жаргалант сумын Сум дундын эмнэлгийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны 3 дугаар улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардал 418808.5 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 8376.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 590781.2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 11815.6 мянган төгрөгөөр тооцов.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Жаргалант сумын Сум дундын эмнэлгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 33057.3 мянган төгрөгөөр буюу 4.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 35,722.90 | 54,743.30 | 19,020.40 |
| Бараа материал | 35,722.90 | 54,743.30 | 19,020.40 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 690,878.00 | 704,914.90 | 14,036.90 |
| Үндсэн хөрөнгө | 1,116,659.10 | 1,177,473.60 | 60,814.50 |
| Хуримтлагдсан элэгдэл | -425,781.10 | -472,558.70 | -46,777.60 |

| | | | |
|---|---|---|---|
| **Нийт хөрөнгө** | 726,600.80 | 759,658.10 | 33,057.30 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 726,600.80 | 759,658.10 | 33,057.30 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 726,600.80 | 759,658.10 | 33,057.30 |

Бараа материалын дансны үлдэгдэл 54743.3 мянган төгрөг болж өмнөх оноос 19020.4 мянган төгрөгөөр өссөн нь эм, боох материал 3977,9 мянган төгрөгөөр, тусгай зориулалтын материал 6859.4 мянган төгрөгөөр, аж ахуйн материал 8221,8 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд цар тахлын үед бэлэн байдлыг хангах зорилгоор Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газраас 6611.8 мянган төгрөг, Жаргалант сумын ЗДТГ-аас 1500.0 мянган төгрөг, Хонгор нутгийн дэвжээ ТББ –аас 120.0 мянган төгрөгийн үнэ төлбөргүй халдвар ариутгалын нэг удаагийн хэрэгсэл авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1177473.6 мянган төгрөг болж өмнөх оноос 60814.5 мянган төгрөгөөр өссөн нь олон улсын төслийн хөрөнгөөр 60057.9 мянган төгрөгийн зөөврийн ариун цэврийн байгууламж үнэ төлбөргүй орлого авч, төсвийн хөрөнгөөр 3099.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан ба сумын ИТХ-ын тогтоолыг үндэслэн 2664.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталсан байна.

Биет бус хөрөнгөнд 275.0 мянган төгрөгийн үнэтэй нярвын программ худалдан авч, ашиглалтгүй болсон 200,0 мянган төгрөгийн архивын программыг аймгийн ИТХ-ын 2020 оны 49 тоот тогтоолыг үндэслэж акталсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 759658.1 мянган төгрөг ба өмнөх оноос 33057.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 623838.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 123099.9 мянган төгрөгөөр буюу 24.6 хувиар өссөн нь 69969.8 мянган төгрөгийн үнэ төлбөргүй орлого нэмэгдэж, улсын төсвөөс олгох санхүүжилт өмнөх оныхоос 41139.3 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

Баянхонгор аймгийн ЭМГ-аас 7250.0 мянган төгрөг нэмэлт санхүүжилтийн дансаар орсон ба 2000.0 мянган төгрөг цалин, 250.0 мянган төгрөг НДШ, 5000.0 мянган төгрөг эм боох материалд зарцуулсан байна.

Нийт зардал 590781.1 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 66049.7 мянган төгрөгөөр буюу 12.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил зардал 47406.2 мянган төгрөг, урсгал засвар 4659.7 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшуулал 4443.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

## 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 572661.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 572661.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 27944.8 мянган төгрөгөөр бууруулж 544717.0 мянган төгрөгөөр баталсан байна.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 544717.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 3581.0 мянган төгрөгийн ажил олгогчоос олгох тэтгэмж урамшууллын зардлын санхүүжилт дутуу ирсэн ба

гүйцэтгэлээр 540653.8 мянган төгрөг зарцуулж 474,1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн.

Цалин, НДШ-ийн зардлыг 402.0 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 39.7 мянга, хангамж бараа материалын зардлыг 39.2 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 8.3 мянган төгрөгөөр тус тус батлагдсан зардлыг хэмнэсэн байна.

| Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|
| ХӨТӨЛБӨР 71601 | 544,717,000.00 | 540,653,840.27 | 4,063,159.73 | |
| АРГА ХЭМЖЭЭ 80101 | 538,717,000.00 | 534,654,530.27 | 4,062,469.73 | |
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 538,717,000.00 | 534,654,530.27 | 4,062,469.73 | |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 538,717,000.00 | 534,654,530.27 | 4,062,469.73 | |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 540,596,000.00 | 540,113,840.27 | 482,159.73 | |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 358,159,300.00 | 357,922,176.27 | 237,123.73 | |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 44,770,500.00 | 44,605,586.00 | 164,914.00 | |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 38,294,900.00 | 38,255,176.00 | 39,724.00 | |
| Хангамж, бараа материалын зардал | 22,504,200.00 | 22,475,021.00 | 29,179.00 | |
| Нормативд зардал | 54,081,600.00 | 54,081,531.00 | 69.00 | |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 12,140,000.00 | 12,139,200.00 | 800.00 | |
| Томилолт, зочны зардал | 1,506,400.00 | 1,505,000.00 | 1,400.00 | |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,139,100.00 | 3,130,840.00 | 8,260.00 | |
| ХӨТӨЛБӨР 71601 | 6,000,000.00 | 5,999,310.00 | 690.00 | 100 |
| АРГА ХЭМЖЭЭ 83112 | 6,000,000.00 | 5,999,310.00 | 690.00 | 100 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 6,000,000.00 | 5,999,310.00 | 690.00 | |
| АРГА ХЭМЖЭЭ 80802 | | | | |
| Нэг удаагийн тэтгэмж урамшил | 41,210,000.00 | 540,000.00 | 3,581,000.00 | 13.1 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 41,210,000.00 | 540,000.00 | 3,581,000.00 | 100 |
| Бусад урсгал шилжүүлэг | 41,210,000.00 | 540,000.00 | 3,581,000.00 | 100 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт дансаар гүйлгээ хийгдээгүй болно.

## 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулахаас 146 мэдээллийг хугацаанд нь байршуулж төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн талаарх мэдээллийг 1,2,3 сард хугацаа хоцроож мэдээлсэн байна.

## 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар итгэл үзүүлж санхүүгийн тайланд аудит хийгдээгүй болно.

## 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1660.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1660.0 мянган төгрөгийн 1 зөрчилд зөрчил арилгах албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар нийт 1660.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1660.0 мянган төгрөгийн 1 зөрчилд зөрчил арилгах албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

| д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд оруулсан | Хугацаа хоцроосон | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 9 | 9 | 0 | 2 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | 0 | |
| 3 | Улирал бүр | 4 | 4 | 4 | 0 | |
| 4 | Сар бүр | 12 | 36 | 36 | 0 | |
| 5 | Тухай бүр | 12 | 96 | 93 | 3 | |
| | Нийт | | 149 | 146 | 3 | 2 |

1. Тус байгууллагад бүртгэлтэй 2018 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ирсэн 1660.0 мянган төгрөгийн үнэтэй, мотоцикл гаалийн бичиггүйгээс улсын бүртгэлийн гэрчилгээ аваагүй, номер дугааргүй байна. Энэ нь Авто тээврийн хэрэгслийн тухай хуулийн 17.1."Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн тээврийн хэрэгсэл өмчилж авснаас хойш 72 цагийн дотор, ашиглалтаас хассанаас хойш нэг сарын дотор аймаг, нийслэл дэх авто тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа байгууллагад бүртгүүлнэ."гэсэн заалт, "Эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Холбогдох баримт материалыг бүрдүүлж мотоциклыг тээврийн хэрэгслийн гэрчилгээ, улсын дугаар авах талаар холбогдох байгууллагуудад хандаж арга хэмжээ авах албан шаардлага хүргүүлэх.

### Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

## 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Жаргалант сумын Сум дундын эмнэлэг нь Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газарт сар бүрийн өглөг, авлагын мэдээг хүргүүлж байсан ба 2020 оны 6-р сараас эхлэж үүссэн эм, боох материалын өглөг 5000.0 мянган төгрөг, ковид цар тахалтай холбогдуулан ажиллагсдад илүү цагийн хөлс олгосонтой холбоотойгоор ххоат-ын өглөг 2000.0 мянган төгрөг, НДШ өглөг 250.0 мянган төгрөг нийт 7250.0 мянган төгрөгийн өглөгийг Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газраас нэмэлт санхүүжилтийн дансаар 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдөр санхүүжилтийг авч урсгал үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлсэн байна.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

***1.Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал***

1.1. *Илрүүлэлт:* Тус байгууллага нь 2018.09.26-ны өдөр 0000439645 тоот Төрийн байгууллагын газар эзэмших гэрчилгээ авсан ба байгууллагын дарга солигдсон байхад өөрчлөлт хийгдээгүй, мөн эрхийн улсын бүртгэлийн Г дугаар аваагүй байгаа нь Газрын тухай хуулийн 23.6. “Аймаг, нийслэл, дүүргийн газрын алба, сумын газрын даамал нь газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээнд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 28.3-т заасан эрхийн улсын бүртгэлийн дугаарыг тэмдэглэнэ.” заалт, “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна

1.2. *Эрсдэл:* Газар эзэмших гэрчилгээнд хуулийн дагуу холбогдох өөрчлөлтийг цаг тухайд нь хийлгээгүйгээс тухайн байгууллагын газар дээр өөр байгууламж баригдах.

1.3. *Өгсөн зөвлөмж*. Газрын тухай хуулийн дагуу газар эзэмших гэрчилгээнд холбогдох өөрчлөлтийг оруулж, гэрчилгээнд Г дугаар шинээр авч баталгаажуулан, хуулийг хэрэгжүүлж ажиллах.

1.4. *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

### *2. Шилэн данстай холбоотой асуудал*

2.1 *Илрүүлэлт*: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн дагуу холбогдох мэдээллийн shilendans@gov.mn сайтад хуулийн хугацаанд үнэн зөв мэдээлсэн эсэхийг шалгахад нийт 149 мэдээлэл байршуулахаас 146 мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж 3 мэдээллийг хуулийн хугацаанаас хоцроож байршуулсан байна.

2.2 *Эрсдэл*: Шилэн дансны мэдээллийн үнэн зөв, хуулийн хугацаанд байршуулаагүй байх

2.3 *Өгсөн зөвлөмж*: Шилэн дансны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1[1], 7.1.3[2] заалтын дагуу шилэн дансанд мөн хуулийн 6 дугаарт заасан төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн талаарх мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдээлж байх.

2.4 *Байгууллагаас өгсөн хариу тайлбар*: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

[1] Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ:

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР ................................................. М.АЛТАНТУЯА
ОГНОО: 2021.02.10

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР................................................. А.ЦЭЭНЯМ
ОГНОО: 2021.02.10

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР................................................. Б.МӨНХБАТ
ОГНОО: 2021.02.10

6417143544
ВЮА0067 9007423

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо | Аудитын нэр: | Жаргалант сумын Сум дундын эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит | Аудитын код: |
|---|---|---|---|
| 2020 | | | БНА-2021/162/СТА-ТШЗ |
| **Шалгагдсан байгууллагын нэр:** | | Жаргалант сумын Сум дундын эмнэлэг | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Тус байгууллагад бүртгэлтэй 1660.0 мянган төгрөгийн үнэтэй, мотоцикл гаалийн бичиггүйгээс улсын бүртгэлийн гэрчилгээ аваагүй, номер дугааргүй байна. Энэ нь Авто тээврийн хэрэгслийн тухай хуулийн 17.1."Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн тээврийн хэрэгсэл өмчилж авснаас хойш 72 цагийн дотор, ашиглалтаас хассанаас хойш нэг сарын дотор аймаг, нийслэл дэх авто тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа байгууллагад бүртгүүлнэ."гэсэн заалтыг зөрчсөн байна. | 1660.0 | Албан шаардлага | Эрхлэгч, нягтлан бодогч | Г.Алтантуяа, Д.Амартүвшин |
| 2 | Тус байгууллага нь 2018.09.26-ны өдөр 0000439645 тоот Төрийн байгууллагын газар эзэмших гэрчилгээ авсан ба байгууллагын дарга солигдсон байхад өөрчлөлт хийгдээгүй, мөн эрхийн улсын бүртгэлийн Г дугаар аваагүй байгаа нь Газрын тухай хуулийн 23.6. "Аймаг, нийслэл, дүүргийн газрын алба, сумын газрын даамал нь газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээнд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 28.3-т заасан эрхийн улсын бүртгэлийн дугаарыг тэмдэглэнэ." заалтыг зөрчсөн байна. | 0 | Зөвлөмж хүргүүлэх | Эрхлэгч, нягтлан бодогч | Г.Алтантуяа, Д.Амартүвшин |
| 3 | Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн дагуу холбогдох мэдээллийн shilendans@gov.mn сайтад хуулийн хугацаанд үнэн зөв мэдээлсэн эсэхийг шалгахад нийт 149 мэдээлэл байршуулахаас 146 мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж , 3 мэдээллийг хуулийн хугацаанаас хоцроож байршуулсан байна | 0 | Зөвлөмж хүргүүлэх | Эрхлэгч, нягтлан бодогч | Г.Алтантуяа, Д.Амартүвшин |
| **ДҮН** | | **1660.0** | | | |

_____oOo___